



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Агт сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/152/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр: Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.dov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-15
3. Аудитын тайлан.....	15-18
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	18-19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 66

танай _____ ны № _____ т

Баян-Агт сумын соёлын
төвийн эрхлэгч Ч.ГАНТУЛГА
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Агт сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Агт сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:/bichighereg/2022A4toot

00600092

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,927,908.20	13,899,553.62
33	АВЛАГА	-	43,249.42
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	43,249.42
35	БАРАА МАТЕРИАЛ	13,927,908.20	13,856,304.20
351	Түүхий эд материал	90,000.00	90,000.00
35110	Тусгай зориулалттай материал	90,000.00	90,000.00
354	Хангамжийн материал	13,837,908.20	13,766,304.20
35410	Бичиг хэргийн материал	197,204.00	145,600.00
35420	Аж ахуйн материал	13,640,704.20	13,620,704.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,282,009,965.94	1,254,566,881.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,282,009,965.94	1,254,566,881.30
392	Биет хөрөнгө	1,274,333,965.94	1,246,890,881.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,349,765,600.00	1,349,765,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(102,736,956.79)	(124,236,956.83)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	24,732,278.00	24,732,278.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,592,478.08)	(19,100,243.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,416,764.00	11,416,764.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,937,910.20)	(7,640,529.00)
39217	Ном	11,686,669.01	11,953,969.01
393	Биет бус хөрөнгө	7,676,000.00	7,676,000.00
39301	Программ хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(100,000.00)	(100,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,676,000.00	7,676,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,295,937,874.14	1,268,466,434.92
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	359,768.30	100,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	359,768.30	100,000.00
413	Өглөг	359,768.30	100,000.00
4136	Бусад өглөг	-	100,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	100,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,295,578,105.84	1,268,366,434.92
51	Засгийн газрын хувь оролцоо	1,295,578,105.84	1,268,366,434.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	601,708,292.85	601,708,292.85
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	601,708,292.85	601,708,292.85
512	Хуримтлагдсан үр дүн	693,869,812.99	666,658,142.07
51210	Өмнөх үеийн үр дүн	693,869,812.99	693,869,812.99
51220	Тайлант үеийн үр дүн	-	(27,211,670.92)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,295,937,874.14	1,268,466,434.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	122,114,206.00	134,060,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,277,406.00	742,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,277,406.00	742,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,277,406.00	742,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	525,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,977,406.00	217,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	119,836,800.00	133,318,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	119,836,800.00	133,318,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	119,836,800.00	133,318,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	149,887,862.72	161,272,570.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	149,887,862.72	161,272,570.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	149,286,445.72	138,217,305.55

Баян-Агт сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	52,093,701.30	47,613,643.22
210101	Үндсэн цалин	40,352,627.30	40,444,177.22
210102	Нэмэгдэл	-	1,149,609.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,741,074.00	6,019,857.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,428,551.00	5,900,675.69
210201	Тэтгэврийн даатгал	4,395,093.00	4,232,690.11
210202	Тэтгэмжийн даатгал	516,805.00	474,146.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	413,485.00	379,138.77
210204	Ажилгүйдлийн даатгал	100,233.00	74,879.71
210205	Эрүүл мэндийн даатгал	1,002,935.00	739,820.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,860,025.00	53,099,998.00
210301	Гэрэл, цахилгаан	310,191.00	151,398.00
210302	Түлш, халаалт	58,549,834.00	52,948,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,159,300.00	474,324.00
210401	Бичиг хэрэг	83,200.00	81,604.00
210402	Тээвэр, шатахуун	326,500.00	118,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	47,100.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	94,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,500.00	105,000.00
2105	Нормативт зардал	600,000.00	40,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	40,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	336,000.00	1,398,000.00
210604	Урсгал засвар	336,000.00	1,398,000.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	58,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	58,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,332,670.00	1,922,280.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,224,670.00	922,280.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,434,198.42	27,710,384.64
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,434,198.42	27,710,384.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	601,417.00	23,055,265.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	21,800,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,700,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	501,417.00	1,254,765.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	501,417.00	1,254,765.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(27,773,656.72)	(27,211,670.92)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(27,773,656.84)	(27,211,670.92)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,708,292.85	-	721,643,469.83	-	1,323,351,762.68
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	601,708,292.85	-	721,643,469.83	-	1,323,351,762.68
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(27,773,656.84)	-	(27,773,656.84)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,708,292.85	-	693,869,812.99	-	1,295,578,105.84
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	601,708,292.85	-	693,869,812.99	-	1,295,578,105.84
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	601,708,292.85	-	693,869,812.99	-	1,295,578,105.84
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(27,211,670.92)	-	(27,211,670.92)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,708,292.85	-	666,658,142.07	-	1,268,366,434.92

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	120,136,800.00	133,843,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	300,000.00	525,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	300,000.00	525,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	300,000.00	525,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	525,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	119,836,800.00	133,318,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	119,836,800.00	133,318,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	119,836,800.00	133,318,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	120,136,800.00	133,793,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	120,136,800.00	133,793,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,535,383.00	110,738,334.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,733,933.00	47,886,359.52
210101	Үндсэн цалин	39,992,859.00	40,444,177.22
210102	Нэмэгдэл	-	1,149,609.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,741,074.00	6,292,573.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,428,551.00	5,930,977.11
210201	Тэтгэврийн даатгал	4,395,093.00	4,262,992.01
210202	Тэтгэмжийн даатгал	516,805.00	474,146.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	413,485.00	379,138.77
210204	Ажилгүйдлийн даатгал	100,233.00	74,879.20
210205	Эрүүл мэндийн даатгал	1,002,935.00	739,820.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,860,025.00	53,099,998.00
210301	Гэрэл, цахилгаан	310,191.00	151,398.00
210302	Түлш, халаалт	58,549,834.00	52,948,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	331,100.00	325,000.00
210401	Бичиг хэрэг	60,000.00	60,000.00
210402	Тээвэр, шатахуун	120,000.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	85,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	90,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	390,000.00	1,478,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	90,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	1,398,000.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	58,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	58,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,704,774.00	1,960,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,596,774.00	960,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	601,417.00	23,055,265.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	21,800,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	21,700,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	501,417.00	1,254,765.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	501,417.00	1,254,765.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	50,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	50,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	50,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	50,000.00
223001	Бусад хөрөнгө	-	50,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(50,000.00)
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр/

Баян-Агт сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	133918600.00	132588834.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	133918600.00	132538834.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	112018100.00	110738334.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	48218900.00	47886359.52
210101	Үндсэн цалин	0.00	0.00	39218900.00	40444177.22
210102	Нэмэгдэл	0.00	0.00	0.00	1149609.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00	9000000.00	6292573.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	6509600.00	5930977.11
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00	4580800.00	4262992.01
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	482200.00	474146.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00	385800.00	379138.77
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	96400.00	74879.20
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	964400.00	739820.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	53418600.00	53099998.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	470000.00	151398.00
210302	Түлш, халаалт	0.00	0.00	52948600.00	52948600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00	325000.00	325000.00
210401	Бичиг хэрэг	0.00	0.00	60000.00	60000.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00	100000.00	100000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, арнутгал	-	-	-	90,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	1,478,000.00	1,478,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-	80,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	-	-	1,398,000.00	1,398,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-	58,000.00	58,000.00
210702	Дотоод албан томилолт	-	-	58,000.00	58,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-	2,010,000.00	1,960,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	1,010,000.00	960,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-	1,000,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	21,900,500.00	21,800,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	21,900,500.00	21,800,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	21,700,500.00	21,700,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	200,000.00	100,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	50,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-	-	50,000.00
223001	Бусад хөрөнгө	-	-	-	50,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	133,843,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	133,318,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	-	-	133,318,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-	525,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	525,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Агт сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Агт сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 албан тоотоор ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баян-Агт сумын соёлын төв нь “Иргэдэд таатай тохилог цэвэр орчин бүрдүүлэх, чанартай, сэтгэл ханамжтай соёлын үйлчилгээг бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Агт сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 149887.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2248.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1573.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Агт сумын соёлын төв нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	0	43249.42	43249.42
Бараа материал	13927.9	13856.3	71.6
Үндсэн хөрөнгө	1405377.3	1405644.6	-267.3
Нийт хөрөнгө	1295937.8	1268466.4	27471.4
Өглөг	359.7	100.0	259.7
Хуримтлагдсан үр дүн	693869.8	666658.1	27211.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1295937.8	1268466.4	27471.4

Авлага: Өмнөх оны үлдэгдэлгүй тайлант онд 43249.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл илүү шилжүүлсэн авлага үүснээр эцсийн үлдэгдэл 43249.4 мянган төгрөгийн авлагатай байна.

Бараа материал: Оны эхний үлдэгдэл 13927.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 13856.3 мянган төгрөг болж өмнөх оноос 71.6 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1750.7 мянган төгрөгийн худалдан авалт хийж 1822.3 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1405377.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1405644.6 мянган төгрөг болж өмнөх оноос 267.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд үнэ төлбөргүй орлого 217.3, төсвийн хөрөнгөөр 50.0 мянган төгрөгийн худалдан авалтаар нэмэгдэж, тайлант онд шилжүүлсэн болон акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр: Өглөгийн дансны эхний үлдэгдэл 359.7 мянган төгрөг, тайлант оны эцсийн үлдэгдэл 100.0 мянган төгрөг байна.

Санхүү байдлын, орлого үр дүнгийн, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

Үүнд: Санхүү байдлын, Үр дүнгийн, Мөнгөн гүйлгээний, Өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баян-Агт сумын Соёлын төв нь 2021 онд Улсын төсвөөс 133.300,0 мянган төгрөг, өөрийн орлогоос 500.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Баян-Агт сумын соёлын төв нь 2021 он Улсын төсвөөс 133.800,0 мянган төгрөг, нэмэлт дансанд гүйлгээ хийгдээгүй, 133.700,0 мянган төгрөгийг зарцуулж 1.200,0 мянган төгрөгийн хэмнэлттэй тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баян-Агт сумын соёлын төв нь 2021 онд нэмэлт дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулах боловч гүйлгээ хийгдээгүй тул хүснэгтээр харуулаагүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баян-Агт сумын соёлын төв нь татвараас авах 12.9 мянган төгрөг, нийгмийн даатгалаас 30.3 мянган төгрөгийн авлага үүссэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна. Санхүүгийн тайланд өглөг авлагыг бүрэн тусгаагүй байсныг тусгуулж ажиллаа.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 145 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба 1 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа ч хугацаа хоцроож мэдээлсэн нь холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 2 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг 2021 оны 06 дугаар сарын 15-ний өдөр хүргүүлсэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Авлага, өглөг үүсгэхгүй ажиллах талаарх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 193.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 143.2 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч ажиллалаа.

4.1 Санхүүгийн тайлантай холбоотой залруулсан алдаа

Үндсэн хөрөнгийн тайланд төсвийн хөрөнгөөр 50000 төгрөгийн ном худалдан авсанг мөнгөн гүйлгээний тайлангийн биет болон биет бус хөрөнгө дансанд тусгаж зардал талаас нь хассан бичилт хийж залруулсан.

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Анхан шатны баримт буюу нэмэгдсэн өртгийн албан татварын баримт дутуу.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг мөрдлөг болгож ажиллах.

2. Өглөгийн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Байгууллагат өгөх 100,000 төгрөгийн өглөг үүссэн нь гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг баримталж ажиллах.

3. Авлагын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Татвараас авах 12,949, Нийгмийн даатгалаас 30300 төгрөгийн авлага үүссэн байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг баримталж ажиллах.

4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Нийт 145 мэдээлэл оруулахаас 1 мэдээлэл хоцроож мэдээлсэн байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд мэдээлэх мэдээллийг цаг хугацаанд нь хоцроохгүй, хуулийн хугацаанд мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		/сая/төгрөгөөр/ Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баян-Агт сумын Соёлын төв	5	193.2	1	0	0	0	0	0	4	143.2